

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ

ЁС ЗҮЙН ХЭСГИЙН ХОРООНООС 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 02

Улаанбаатар хот

№	ҮЙЛ АЖИЛЛАГАА	БИЕЛЭЛТ			
1	Хорооны хуралдаан	<p>Ёс зүйн хэсгийн хорооны хурлаар дараах асуудлуудыг авч хэлэлцэв. Ёс зүйн хэсгийн хорооноос хийсэн хурлын тоо - 3 Авч хэлэлцсэн асуудал -3, 100% шийдвэрлэв. Нийт шийдвэрлэсэн асуудлын тоо - 4 Үүнээс: 2025 оны төлөвлөгөө - 1</p> <ol style="list-style-type: none"> ЭМЯ, НЗДаргын шагналд нэр дэвшигчдийн ёс зүйн дүгнэлт Ёс зүйн хэсгийн хороонд ирсэн 1 гомдлыг хэлэлцэн шийдвэрлэж иргэнд хуулийн хугацаанд хариуг өгсөн. Нийт 2 гомдол ирсэн 1 нь үндэслэлгүй байсан. 1 гомдлыг иргэн өөрөө буцаасан. 			
2	<p>Ёс зүйн талаар сургалт</p> <ol style="list-style-type: none"> 2025 оны эхний хагас жилд тус төвийн эмч ажилчдад ёс зүй харьцаа хандлагын 2 удаагийн 4 цагийн сургалтад 410 ажилтан хамрагдсан. Үүнд: Эмнэлгийн ажилтны ёс зүй харьцаа хандлагын үйлчлүүлэгчтэй харилцах талаар 3 өдрийн 3 цагийн вакумжуулсан сургалтыг төвийн үйлдвэрчний хороотой хамтарч зохион байгуулсан. Нийт 410 хамрагдсан. Үүнд: <ol style="list-style-type: none"> АУ-ны доктор, дэд профессор, ХЗУ-ны магистр, “Эрх зүйн боловсрол ба Эрүүл мэнд” ТББ-ын захирал М.Цэрэнбат “Ёс зүй, ёс суртахуун, зан суртахууныг Эрх зүйн хэм хэмжээний үүднээс тайлбарлах нь” сэдвийн хүрээнд дараах сэдвүүдээр сургалт зохион байгуулсан. 	<p>Эмч эмнэлгийн дээд мэргэжилтэн</p> <p>- 266</p> <p>- 261</p>	<p>Эмнэлгийн тусгай мэргэжилтэн</p> <p>- 31</p> <p>- 31</p>	<p>Бусад эмнэлгийн мэргэжилтэй ажилчид</p> <p>- 113</p> <p>- 118</p>	<p>Иргэд</p>

- ✦ Эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ.
- ✦ Ёс зүйн зөрчил, түүнд холбогдох эрх зүйн актууд.
- ✦ Эрх зүйн бусад зөрчлүүд болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил.



2."Зэлэм сургалтын төв"-тэй хамтран "Харилцан адилгүй зан төлөвийг удирдах нь" сургалтыг Зэлэм тархи сургалтын байгууллагын сургалт хариуцсан захирал, сургагч багш, көүч М.Оюун-Эрдэнэ удирдан өөрсдийнхөө зан төлөвөө тодорхойлж, харилцан адилгүй зан төлөвтэй хүмүүстэй хэрхэн үр дүнтэй харилцаж, ажлын бүтээмжээ сайжруулах арга барилд суралцсан. /1 цаг сургалт 30 ажилтан/





НЭМГ-ын дэргэдэх салбар хорооноос зохион байгуулсан "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, тулгамдсан асуудлууд" сэдэвт сургалтанд 2025 оны 05-р сарын 16-нд 2 ажилтан хамрагдсан.



30

2

<p>“Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ” сэдэвт хэлэлцүүлэгт 1 ажилтан хамрагдсан.</p> 	1			
<p>Салбаруудын хэмжээнд ЭМС-ын 2019 оны А/406 тоот тушаалын хэрэгжилтийг хангах, эмч ажилчдын харьцаа хандлага, ажлын хариуцлага, сахилга батыг сайжруулах, “Ёс зүй, харилцаа хандлага”-ыг нэмэгдүүлэх чиглэлээр ажлын төлөвлөгөөг боловсруулан тусламж ээлж тус бүр хэрэгжүүлж ажиллалаа. Салбар тус бүр дотооддоо нийт эмч нараа 100% хамруулан сургалт зохион байгуулж, тушаалын мэдлэгийг шалгах сорил авч үнэлгээ хийсэн.</p>	50	10		
				
<p>Мэдлэг шалгах өмнөх сорилын үнэлгээгээр 80,5% үнэлгээтэй, ЭМС-ын А/406 тоот тушаалаар давтан мэдээлэл сургалт хийсэн. Дундаж үнэлгээ 86.9%. Үр дүн: Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрх зүйн хэм хэмжээ, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хууль тогтоомжийн мэдлэгтэй болсон. “Эмчээ алдаршуулъя” аяны хүрээнд салбарын эмч нараас “Хамгийн хамгийн”-аар ажлын үзүүлэлтээр 5 номинацаар 5 салбарын 5-н ахлах эмч,</p>	20	20		

эмч нарыг шалгаруулж, цалингийн 20%-иар урамшуулж гарын бэлэг өгсөн. Үүнд: Салбаруудын хамгийн их ЗГ-ын 1111-ээс ёс зүй, харьцаа хандлага, эмнэлэгийн тусламж үйлчилгээгээр талархал авсан эмч нар, Хамгийн их сэтгэлийн үг" талархлын хайрцгаар хүлээж авсан, хамт олонч харилцаа хандлага сайтай эмч нарыг шалгаруулж, гарын бэлэг, цалингийн 20%-р урамшуулсан. Үүнд:



Н.Сэржмядаг танаа: "Сайхан сэтгэлтэй эмч тандаа баярлаж явдаг шүү". ХУС үйлчилгээний албанаас. ХУСалбарын 3-р ээлжийн их эмч Н.Тунгалаг танаа:

"Төрсөн биеээ түмэнд зориулсан
Түмний судсаар зүрх нь цохилсон
Хамаг олны итгэлийг хүлээсэн
Халамжит эмч тандаа баярлалаа.

Ажилд нь өндөр амжилт,
Амьдралд нь аз жаргал хүсье".

Хүндэтгэсэн. Үйлчлэгч

У.Эрдэнэчимэгээс.

2025 оны 11-р сарын 15-ны өдөр "Харилцан Адилгүй зан төлөвийг удирдах, үйлчлүүлэгчид анхны сэтгэгдлийг эерэгээр төрүүлэх" сэдэвт 4 цагийн сургалтыг Хан-Уул салбарын эмч нарт Soft skills сургагч багш С.Буян-орших эмчийг урьж зохион байгууллаа. Сургалтад дасгал ажил ажиллаж, бүлгийн ярилцлага хийсэн.

Үр дүн: Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, харилцан туршлага солилцох, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, оновчтой зохион байгуулалт, хамтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, харьцаа хандлага, нийтэч нөхөрлөлийг батжуулсан арга хэмжээ болсон.

19

2

3	Ёс зүйн асуудлаар зохион байгуулсан үйл ажиллагаа	<ol style="list-style-type: none"> 1. Нийт 5 салбараас ёс зүйн хэсгийн хороог шинэчлэхээр санал авсан. 2. Байгууллагын вэб сайт, салбаруудын мэдээллийн самбарт мэдээллүүдийг байршуулсан. 3. “Эерэг хандлага түгээцгээе” өдөрлөг зохион байгуулсан. Түргэн тусламжийн үйл ажиллагааг сурталчлах эрүүл мэндийн зөвлөгөө өгч гарын авлага 200 гаруй иргэдэд мэдээлэл тараасан 4. ЭМС-ын 2019 оны А/406 тоот тушаалын хэрэгжилтийг хангах, эмч ажилчдын харьцаа хандлага, ажлын хариуцлага, сахилга батыг сайжруулах ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор “Ёс зүйн сарын аян”-ыг зарлаж, удирдамж, хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан тусламж үйлчилгээ хариуцсан орлогч даргаар батлуулан, хэрэгжүүлж ажилласан. 5. Шинээр ажилд орж байгаа ажилтнуудад эмнэлэгийн мэргэжилтний ёс зүйн ЭМС-ын А/406-р тушаал, Засгын газрын 109-р тогтоол, байгууллагын дотоод хэм хэмжээ, байгууллагаас мөрдөгдөж байгаа үйл ажиллагааны журам, хууль тогтоомж уншуулж гарын үсгээр баталгаажуулсан. 6. 2025 онд нийт 60 эмч, 10 сувилагч, 10 бусад ажилтан албан хаагчид дээрх тушаал зааврыг танилцуулж, гарын үсгээр баталгаажуулсан. 			
4	Эвлэрүүлэн зуучлалын хийсэн	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг эвлэрүүлсэн тоо 0	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг эвлэрүүлсэн 0	Үйлчлүүлэгч эмнэлийн мэргэжилтнүүдийг эвлэрүүлсэн тоо 0	Ёс зүй харьцаа хандлагын гомдол гараагүй тул эвлэрүүлэн зуучлалын

			хийгдээг үй болно
5	Ил тод байдал	<p>Цахим хуудсанд байршуулсан ёс зүйн үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл, ёс зүйн аяны хүрээнд хийгдсэн танилцуулга бичлэгүүд.</p> <ol style="list-style-type: none"> 2025 оны Ёс зүйн хэсгийн хорооны тайлан, 2025 төлөвлөгөө байршуулсан. Эмч ажилчдад ирсэн нийт талархлыг 14 хоног тутам 18 удаа вэб сайтад байршуулсан. Тус төвийн эмч, сувилагч, жолооч нарт засгийн газрын 11-11 утсаар нийт 516 талархал ирсэн. Талархал авсан ажилчдын улирлын ажил дүгнэх үзүүлэлт оруулж урамшуулал олгосон. Ирсэн талархлыг вэб сайтад байршуулсан. Ёс зүйн аяны хүрээнд хийгдсэн танилцуулга, бичлэгүүд. <p>19 сарын 20-ний өдөр ХУД-ийн 103 парлтай тусламжийн Э.р аэлжийн эмч Б.Төмөр, жолооч Б.Анжвар нар нь дуудлага авч ирээ мийн хүүд тусламж үйлчилгээ үзүүлэн лалилаа нитлалын эмнэлэгт цаг өндөргүй зургаж амь насыг нь өдөр аавгайгаж өгсөн юм. Ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг, өргөсөн танг арч ган үнэмч, түргэн шуурхай үйлчилдэг, эрдэнэцэг, ханданч и бэйгээ хүндийг тэргэн залууч, дулаан сонголттой талархал ажил үйлсэд нь амжилт, амьдралд нь сайн сайхан бүхийг хүсэн өргөж талархал илэрхийлж байна. Эмчлүүлэгч Цэнджаргал.</p> <p>Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №11, G240104044</p>	<p>Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №76, G240213028</p> <p>6 настай хүүхэд мвань маш өндөр халуурсан тул усанд оруулж байх үед анхаарал алдсаны улмаас усан дотор таталт өгч ус залгиж амь насанд нь эрсдэл үүссэн байхад нийслэлийн ХУД-ийн түргэн тусламжийн эмч Б.Төмөрөө, жолооч Б.Анжвар нар түргэн шуурхай ирж анхны тусламж үзүүлж амь насыг нь аварч дараагийн шатлалын эмнэлэгт хургаж өгсөн лавдалд маш их баярлаж байна. Та бүхийн ажилд өндөр амжилт хүсье. БЗД-ийн 15-р улирлын иргэн П.Олгий</p> <p>№289, C240528019</p> <p>103-н жолооч Д.Алтангарал, эмч Д.Будханд нартаа маш их баярлалаа. Манай авын бие муудаад түргэн тусламж дуудахад түргэн шуурхай ирж эрүүл мандийн тусламж үзүүлж амь насыг нь аварсанд баярлалаа. Ажлын амжилт хүсье. БГД-ийн 18-р хорооны иргэн Ж.Цэрэндондог</p>
6	Бусад ажил	<ol style="list-style-type: none"> “Ажилтан бүр байгууллагын соёлыг дэмжье” аян 2025.02.14-28 <ul style="list-style-type: none"> 5s-ийн тухай, чанарын арга, хэрэгслийн талаарх сургалт орсон. Салбаруудын хүрээнд өрөө бүрийн эмх цэгц, эрсдэл Халдварын сэргийлэлт Эмийн сан Сүлжээ болон компьютертой холбоотой үйл ажиллагаа Албан хэрэг хөтлөлтийн стандарт зэргийг хангах үнэлгээ хийхэд дундаж үнэлгээ 81% байсан. Үүрэг даалгавар өгч, давтан хяналтаар дундаж үнэлгээ 90% болсон. 	

1. “Эмчээ алдаршуулъя” аян: 202.03.14-31

- Эмч нарт иргэдээс ирсэн мэндчилгээ, видеог салбарын группэд байршуулсан.



Эмч нарын урам зориг, бахархал нэмэгдсэн.

2. “Нэгнээсээ суралцъя” аян
2025.04.01-05.01
- ИМУ

- Сургалт, дадлага
- Ёс зүй харьцаа хандлага ЭМС А/406-р тушаал
- Түгээмэл үйлдлийн стандартын дагуу уян зүү тавих гэх мэт олон талт үйл ажиллагаа явагдан эмч, жолооч нарын багаар ажиллах, гардан үйлдлийн чадвар, эмч эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгчтэйгээ харьцах харьцаа хандлага, ур чадвар, мэдлэг сайжирсан.

3. “Цэвэр гар- таны амь насыг аварна” аян 2025.04.16-05.01

- Гар халдваргүйжүүлэх орчин нөхцөлийг үнэлэх, бүрдүүлэх
- Ажлын байран дээрх сургалт, дадлага сургуулилт, үнэлгээ хийх
- Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Заавар батлах тухай” А/537 дугаар тушаалын талаар давтан мэдээлэл, сургалт хийх зорилтын хүрээнд: Гар угаах үнэлгээг ахлах эмч нар ээлжийн эмч нарт хийв. Хамрагдалт 100%, сургалтын өмнөх үнэлгээ 80%, дараах үнэлгээ 90% болж сайжирсан.

4. "0-16 насны хүүхдийн өвчний оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоог сайжруулах" өдөрлөгийн хүрээнд:



- 2025 оны 2-р сарын 24-өөс 3-р сарын 20-ны өдрийн хүүхдийн 270 дуудлагын хуудаст ИМУ хийсэн
 - Эмч нарт "0-16 насны хүүхдийн оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо", "Эмчийн ёс зүй-хүүхэд" сэдэвт сургалтууд орсон.
 - Хүүхдийн дуудлагын чанар үзлэгийг сайжруулах зорилгоор 108 асуулттай АХА зохион байгуулсан. Ирц 100% 20 эмч оролцсон.
 - Үр дүнд: Ур чадвар мэдлэг сайжирсан.
5. "Эрдмийн чуулган-2025", "Түргэн тусламжийн шинэчлэлд салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэе" уриан дор эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан. Үүнд: Эрдэм шинжилгээний илтгэлд тавигдах шаардлага хангасан илтгэлүүдийг 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор tsendjav.2018@gmail.com цахим хаягаар хүлээн авч, 2025 оны 04 сарын 05-ны өдөр шалгарсан илтгэлүүдээр зохион байгуулсан.



Нийслэлийн түргэн тусламжийн төвийн дуудлагын тусламж үзүүлээд, нас барсан тохиолдлыг судалсан дүн
Нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээн дэх гэрийн төрөлтийн гурван жилийн судалгаа

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн дуудлагын 2024 оны зүрхний шигдээсийн тохиолдлын судалгаа

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2024 оны угаарын хийн хордлогын дуудлагад хийсэн дүн шинжилгээ гэх мэт илтгэлүүд оролцож дараах шагналуудаар шагнагдсан. Үүнд:

Эрдмийн чуулган амжилттай болж, шагналын хур буулаа.

1. ЭШХурлын тэргүүн байр СХДарга М.Наранбайгал

2. ЭШХурлын гутгаар байр Б.Эрхэмболд

3. Залуучуудын холбооны шагналаар Н.Оюунгэрэл,

Б.Саруулболд, Э.Цэнгэл, М.Амаржаргал

4. Хамгийн их дуудлага үзсэн эмч: Ж.Лосолмаа

5. Харилцаа хандлага сайтай эмч: М.Золбаяр

6. Дуудлагын хуудас сайн бичдэг эмч: А.Золжаргал

7. Баг хамт олноо сайн удирдан ЗБдаг ахлах эмч Б.Эрхэмболд

8. Хамгийн олон талархал авсан салбарын эмч А.Номин-Эрдэнэ

Хамт олондоо баяр хүргэе ээ 🍎🍌🍌🍌

6. 2025.01.03 МҮОНТ-ийн “Өглөө” нэвтрүүлгээр ТТӨ-ний дэгдэлт, иргэдийн ЭМБ, түргэн тусламжийн дуудлагын ачааллын талаар ярилцлагад оролцсон.



7. “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”, “Эр цэргийн бахархлын өдөр”, “Дэлхийн эмч нарын өдөр”, “Олон улсын сувилагч нар”-ын өдрүүдийг угтан олон талт ажлуудыг зохион байгуулсан. Үүний үр дүнд нийт ажилчдын харьцаа хандлага сайжирч, эмч мэргэжлээрээ бахархах сэтгэл ханамж нэмэгдсэн.



8. "Улаанбаатар марафон-2025" эмч нар идэвхтэй оролцсон.



Үр дүн: Нийт ажилчдын харьцаа хандлага сайжирч, эмч мэргэжлээрээ бахархах сэтгэл ханамж нэмэгдсэн.

9. "Ёс зүйтэй харилцааг өөрөөсөө, хамт олноосоо эхэлье" 2 сарын аяныг байгууллагын хэмжээнд 2025 оны 10-р сарын 23-аас 12-р сарын 23 хүртэл зохион байгуулж байна. Аяны хүрээнд 1. Хан-Уул салбарын уриа "НЭГ ЗҮРХ, НЭГ ХАМТ ОЛОН" 2. Чингэлтэй салбарын уриа "НЭГ ДУУДЛАГА, НЭГ АМЬДРАЛ, НЭГ ҮЙЛДЭЛ, НЭГ ИТГЭЛ" 3. Баян-зүрх салбарын уриа "ЭРЭГ ХАНДЛАГА-ӨӨРИЙМСӨГ СЭТГЭЛ-ТАСРАЛТГҮЙ СУРАЛЦАЖ, ТАНД ҮЙЛЧИЛНЭ", 4. Дуудлага хүлээн авах нэгжийн уриа "ЁС ЗҮЙГЭЭ ЭРХЭМЛЭЭ-ЭРҮҮЛ ИРЭЭДҮЙГ БҮТЭЭЭ", 5. Сонгино-хайрхан салбарын уриа "ЗӨВХӨН БИ ..." хандлагыг өөрчилж "ХАМТЫН СОЁЛЫГ БҮТЭЭЭ" Төв салбарын уриа "ЁС ЗҮЙГ ЭРХЭМЛЭЭ, ЭРҮҮЛ ИРЭЭДҮЙГ БҮТЭЭЭ" уриатайгаар салбарууд тус аянд нэгдэн байгууллагын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлж, харилцаа хандлага, ажлын сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх, ёс зүй, сахилга хариуцлагаар манлайлагч нарыг тодруулах, иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготойгоор салбарын ээлж хамт олон төлөвлөгөө гарган, салбарын эмч нарын, байгууллагын телеграмм групп, face bookд байрлуулан ажиллаж байна. Үүнд:

Ёс зүйн аяны хүрээнд Сонгино-хайрхан Салбар 11-р сарын 15-ны өдөр салбарын нийт 21 эмч нарыг хамруулан сургалт хэлэлцүүлэг зохион байгуулсан.



2025 оны 11-р сарын 15-ны өдөр "Харилцан Адилгүй зан төлөвийг удирдах, үйлчлүүлэгчид анхны сэтгэгдлийг эергээр төрүүлэх" сэдэвт 4 цагийн сургалтыг Хан-Уул салбарын 19 эмч нарт Soft skills сургагч багш С.Буян-орших эмчийг урьж зохион байгууллаа. Сургалтад дасгал ажил ажиллаж, бүлгийн ярилцлага хийсэн.



Чингэлтэй Салбар ажлын нэг болох өдөрт нэг "Эшлэл" аян зарлаж хэрэгжүүлж байна."Та бүхэн өглөө ажилдаа ирэхдээ үүдэнд наасан эшлэлээ уншиж байгаарай" баярлалаа танд.



Төв салбар "Ёс зүйг эрхэмлэе эрүүл ирээдүй бүтээе" гэсэн уриатай байгууллагын ажлаа сурталчилсан видео бичлэг хийж, иргэдэд сурталчилсан.



Чингэлтэй салбар “Нэг дуудлага-Нэг амьдрал, Нэг үйлдэл-Нэг итгэл” ёс зүйн уриан дор доорх видеог бүтээ ажлаа сурталчлан таниулж байна.



Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх, ёс зүйг чанаржуулах эмч эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн судалгааг бүх ажилчдаасаа авч байна.



Автобааз, инженер техникийн алба тусламж үйлчилгээнд ажиллаж байгаа автомашинууддаа “Зөв сэтгэлгээг бид, Зөв алхмыг та 😊” санамж, стикер байршуулж, хувцаслалтаараа жигдэрч, ёс зүйн булан байгуулан, салбар бүрт саналын хайрцаг аялуулан инженер техникийн алба болон жолооч нарын талаарх саналыг авч байна. Ёс зүйн буланд хууль, хэм хэмжээ, талархал, өмнөх сарын манлайлагчид, энэ сарын үзүүлэлт жолооч бүрийн нэрээр нийтэд ил тод байрлуулж өдөр тутам тэмдэглэл хөтөлсөн.

Дээрх саналын хайрцагт

-Хамгийн найрсаг

-Хамгийн тусч

- Хамгийн түшигтэй
- Хаягт хамгийн мэргэн
- Хамгийн цэвэрхэн хувцастай
- Хамгийн цэвэрч
- Хэзээд бэлэн байдаг дагалдах хэрэгслүүд
- Хамгийн царайлаг
- Хамгийн өрөвч
- Хамгийн ур чадвартай гэх мэтээр та хувьдаа тодорхойлон нэрийг бичиг хайрцагт хийж байна. Баярлалаа 😊




Үр дүн.

Хамт олны харилцаа хандлага, ажлын байрны сахилга хариуцлага нэмэгдэж, эмч нарын мэдлэг ур чадвар сайжирч, иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж чанаржиж, байгуулахынхаа онцлогийг сурталчлан таниулж, иргэдийн эрүүл мэндийн ёс зүйн боловсролыг 100%-иар нэмэгдүүлсэн.

ХЯНАСАН:

ЁС ЗҮЙН ХЭСГИЙН ХОРООНЫ ДАРГА



Д.ДАРИЙМАА

НЭГТГЭСЭН:

ЁС ЗҮЙН ХЭСГИЙН ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.АКЕРКЕ